

БАТЛАВ:
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД

Ж.БАТ-ЭРДЭНЭ

“АВТО ЗАМЫН ЧАНАР-ҮР АШИГ” СЭДЭВТ АВТО ЗАМЫН САЛБАРЫН УДИРДАХ
АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨНӨӨС ГАРСАН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА
ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээний нэр	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах байгууллага
<i>Нэг. Төрийн болон төрийн бус байгууллагуудын чиглэлээр</i>			
1.	Авто замын талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулж, Засгийн газраар батлуулах	2018/10	ЗТХЯ
2.	Авто замын хуулийг дагаж мөрдөх журмын төслүүдийг батлуулан, хуулийг сурталчлан таниулах, хэрэгжилтийг үр дүнтэй хангах ажлыг тогтмол зохион байгуулах	Жилдээ	ЗТХЯ
3.	Авто замын асуудал хариуцсан төрийн байгууллагын бүтэц, дотоод зохион байгуулалтыг боловсронгуй болгож, ажил үүргийн давхардлыг арилгах, шат дамжлагыг багасгах	2018/10	ЗТХЯ
4.	Авто замын тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан Авто замын судалгаа шинжилгээ, хөгжлийн асуудал хариуцсан байгууллагын чиг үүргийг хуулийн дагуу “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-т шилжүүлэх асуудлыг судалж, шийдвэрлэх.	2018/09	ЗТХЯ, ЗТХТ
5.	Үндэсний зам барилгын болон засвар арчлалтын компаниудыг чадавхижуулах асуудлыг бодлогын хүрээнд дэмжих	Жилдээ	ЗТХЯ, ЗТХТ
6.	Салбарын инженер техникийн ажилчдын мэргэжлийг дээшлүүлэх, зэрэг дэв олгох сургалтуудыг болон Авто зам, замын байгууламжийг барих засварлах тусгай зөвшөөрөл олгох зэрэгтэй холбогдсон зарим ажил, үйлчилгээг салбарын төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх чиглэлээр хамтран ажиллах	Жилдээ	ЗТХЯ, МАЗХ
7.	Олон улсын Зөвлөх инженерүүдийн холбооны ФИДИК-ийн гэрээг Монгол орны нөхцөл байдалд тохируулан хэрэгжүүлэх асуудлыг судлаж авто зам барилга, арчлалт, засварын ажлын гэрээнд Захиалагч, гүйцэтгэгчийн хүлээх үүрэг, хариуцлагыг сайжруулахад чиглэгдсэн эрх зүйн зохицуулалтыг тусгах	2018/09	ЗТХЯ, ЗТХТ, МАЗХ
8.	Авто замын тухай хуульд заасан авто замын төлөвлөлтийн шатнаас авахуулан зураг төсөл боловсруулах, зураг төсөлд экспертиз хийх, зам барилгын ажлыг хэрэгжүүлэх, ашиглалтад авах зэрэг бүх шатны үйл ажиллагаан дахь зөрчлийг тогтоох, хариуцлага тооцох, гарсан хохирлыг бүрэн барагдуулахтай холбоотой асуудлыг Зөрчлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх	2018-2019	ЗТХЯ, ЗТХТ, МАЗХ


9.	Салбарын үйл ажиллагаа эрхлэгч байгууллага, аж ахуйн нэгжүүдийн ажил, үйлчилгээний түүх, чанар стандартын хангасан эсэхийн талаарх нэгдсэн судалгаа, мэдээллийн санг бий болгох, үйл ажиллагааг тогтмолжуулах	Жилдээ	ЗТХЯ, ЗТХТ, МАЗХ
10.	Олон улс, улсын чанартай авто замын ашиглалтыг сайжруулах, мэдээллийн технологид суурилсан хяналтын нэгдсэн тогтолцоог бий болгох зорилгоор тээврийн хэрэгслийн даацийг хэмжих автомат төхөөрөмж, төлбөрийн цахим систем, хяналтын камерийн иж бүрэн тоноглол, программ хангамжийг судлан шийдвэрлэж эхний шатанд 1-2 цэгт суурилуулах, цаашид цэгүүдийн тоог үе шаттайгаар нэмэх	Жилдээ	ЗТХЯ, ЗТХТ
11.	Олон улс, улсын чанартай хатуу хучилттай 6235 км авто замын тэмдэг, тэмдэглэлийг стандартын дагуу шинэчлэх ажлыг зохион байгуулах	Жилдээ	ЗТХЯ, ЗТХТ
12.	Зам, тээврийн хөгжлийн сайдын дэргэд Авто замын мэргэжлийн зөвлөлийг байгуулан ажиллуулах	2018/05	ЗТХЯ, ЗТХТ, МАЗХ
13.	Төмөр замын бүтээн байгуулалтад үндэсний авто замын компаниудыг оролцуулж төмөр замын суурь далан, хиймэл байгууламж, гүүрийн барилгын ажлыг авто замын компаниудаар гүйцэтгүүлэх талаар дэмжиж ажиллах	Жилдээ	ЗТХЯ
<i>Хоёр. Авто замын барилга, арчлалт, засварын ажлын чиглэлээр</i>			
1.	Авто замын чанар, үр ашгийг дээшлүүлэхэд инженер техникийн ажилтнуудын үүрэг оролцоог нэмэгдүүлж, мэдлэг чадвар, ёс зүйн хариуцлагыг өндөржүүлэх, компанийн менежментийг сайжруулах	Жилдээ	Гүйцэтгэгч байгууллага, АЗЗА компаниуд
2.	Авто замын барилга, арчлалт, засварын компаниуд гүйцэтгэлийн чанар, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэгдсэн дотоод хяналтын тогтолцоог бий болгох асуудлыг судалж шийдвэрлэх	Жилдээ	Гүйцэтгэгч байгууллага, АЗЗА компаниуд
3.	Авто замын барилга, засварын ажилд хямд өртөг бүхий орон нутгийн чанарын шаардлага хангасан материалыг лабораторийн шинжилгээ судалгааны үндсэн дээр түлхүү ашиглах	Жилдээ	Гүйцэтгэгч байгууллага, АЗЗА компаниуд
4.	Олон улсын болон улсын чанартай авто замд "Хөдөлгөөнт эргүүл"-ийн багийг "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ, АЗЗА-ын компаниудтай хамтран зохион байуулж, авто замаар зорчих тээврийн хэрэгслийн даацад үзлэг, шалгалт хийх	Жилдээ	ЗТХЯ, ЗТХТ АЗЗА компаниуд
5.	Монгол Улсын авто замын сүлжээний орон зайн мэдээллийн санг байгуулж, хөгжүүлэх	Жилдээ	ЗТХЯ, ЗТХТ АЗЗА компаниуд

Гурав. Зураг төсөл, эрдэм шинжилгээ судалгаа, зөвлөхийн үйл ажиллагааны чиглэлээр

1.	“Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах ажлын чанар болон хариуцлагын тогтолцоог сайжруулах	Жилдээ	ЗТХТ, Зөвлөх компаниуд
2.	Авто замын салбарын одоо мөрдөгдөж байгаа норм, норматив, техникийн баримт бичгүүдэд дүгнэлт гаргаж, боловсронгуй болгон сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, мөрдөж ажиллах	Жилдээ	ЗТХТ, Зөвлөх компаниуд
3.	Монгол орны байгаль, зам-цаг уурын нөхцөлд тохирсон дэвшилтэт техник технологийг нэвтрүүлж, замын байгууламжийн хийц бүтээц, чанарыг сайжруулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх	Жилдээ	ЗТХТ, Зөвлөх компаниуд

ХЯНАСАН:

АВТО ЗАМЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ
ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ДАРГА


Д.ДОРЖХАНД

БОЛОВСРУУЛСАН:

АВТО ЗАМЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ
ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН


Д.ЗАГДРАДНАА